



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2020 оны 10 сарын 19 өдөр

Дугаар 102

Мандалговь

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 30 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг. Сайнцагаан сумын Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 15,000,000 (арван таван сая) төгрөгийн балансын үнэтэй, 15,000,000 (арван таван сая) төгрөгийн үлдэгдэл өртөгтэй приус 30 маркийн автомашиныг Дундговь аймгийн Цагдаагийн газарт балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

Хоёр. Сайнцагаан сумын Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Оюунчимэг), Дундговь аймгийн Цагдаагийн газрын дарга (Г.Наранбаатар) нарт дор дурдсан арга хэмжээг авч ажиллахыг даалгасугай. Үүнд:

- 2.1 Хөрөнгө хүлээлцэх ажлыг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтад дор холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;
- 2.2 Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;
- 2.3 Энэ тогтоолын биелэлтийг 2020 оны 4-р улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

Гурав. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (О.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА

С.СҮХБААТАР





Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2020 оны 10 дугаар сарын
19-ний өдрийн 102 тогтоолын хавсралт

Сайнцагаан сумын балансаас балансад шилжүүлэх тээврийн хэрэгслийн мэдээлэл

Д/Д	Тээврийн хэрэгслийн төрөл	Марк	Улсын бүртгэлийн		Үйлдвэрлэсэн он	Ашиглалтад орсон огноо	Нийт гүйлт /км/	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэх өртөг
			Сери	дугаар						
1	Суудлын	Приус-30	ДУА	07-06	2010он	2020он	100,000	15,000,000	0	15,000,000
Нийт дүн										
								15,000,000		15,000,000
								/арван таван сая/ төгрөг		/арван таван сая/ төгрөг